



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 05 сарын 11 өдөр

Дугаар А/248

Есөнбулаг сум

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсэг, Үнэлгээний хорооны 2026 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 383 дугаар зөвлөмжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжигдэх ГААХААГ/20260202038 дугаартай Баян-Уул сумд Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд угаалга, ариутгал, халдваргүйтэлийн тусгай зориулалтын машин худалдан авах ажлыг "Дэлгэр-Эрин" ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлэх эрхийг Хүнс, хөдөө аж ахуйн газар (Ж.Очир)-т олгосугай.

2.Ажил гүйцэтгэх хугацаа, техникийн тодорхойлолт зэргийг үндэслэн холбогдох хууль, журмын дагуу эрх үүрэг захиалагчийн хяналт, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгаж, хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар (Ж.Очир)-т үүрэг болгосугай.

3.Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтэс (Д.Чинзориг), Санхүү, төрийн сангийн хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ), Хяналт, шинжилгээ-үнэлгээний хэлтэс (Д.Буянхишиг)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ